

Асуулт	Хариулт
<p>A.1 Битүүмжилсэн цаасан эх хувийг хүргүүлэхийн тулд Монгол улсруу биечлэн төлөөлөгч илгээх шаардлагатай эсэх, эсвэл шуудан/каргоор илгээж болох эсэхийг тодруулж өгнө үү.</p>	<p>X.1 Битүүмжилсэн цаасан эх хувийг илгээхдээ шуурхай хүргэлтийн үйлчилгээ (жишээлбэл, DHL эсвэл EMS)-г ашиглаж болно. Баримт бичгүүдийг 5 дугаар сарын 11-ний өдрөөс өмнө заавал хүргүүлнэ үү.</p>
<p>A.2 Баримт бичигт дурдсан “үйлдвэрийн менежментийн системийн талаарх мэдээлэл” гэсэн нэр томъёоны утгыг тодруулж өгнө үү. Мөн үүнд ямар агуулга багтах ёстой талаар жишээ өгч тайлбарлаж өгнө үү.</p>	<p>X.2 Үйлдвэрийн үйл ажиллагааг хянах, хяналт тавих, оновчлох зорилгоор ашиглаж буй зохион байгуулалтын системүүдийн талаарх тайлбарыг ирүүлнэ үү. Үүнд дараах зүйлсийг багтааж болох боловч үүгээр хязгаарлагдахгүй:</p> <ul style="list-style-type: none"> • Үйлдвэрлэлийн удирдлагын систем • Эрчим хүчний менежментийн систем • Засвар үйлчилгээний менежментийн систем • Нөөц болон материалын удирдлагын систем • Бодит цагийн хяналтын систем • Чанарын удирдлагын систем г.м
<p>A.3 Хэрэв бид албан ёсны төрийн байгууллагын вэбсайтаас татаж авсан холбогдох хуудсуудын PDF хувийг зөвхөн нотлох баримт болгон ирүүлбэл, үүнийг хүчинтэйд тооцох уу?</p>	<p>X.3 Хэрэв мэдээлэл нь танай компани хууль ёсны дагуу үйл ажиллагаа явуулдаг эсэхийг баталгаажуулах боломжтой нээлттэй, албан эх сурвалжаас авсан бол тухайн мэдээллийн PDF хувилбарыг нотлох баримт болгон хүлээн зөвшөөрнө.</p>
<p>A.4 Танай зүгээс тендерийн баримт бичгийн бүрдлийг үнэн зөв эсэхийг шалгах мөн ямар нэгэн алдаа байгаа эсэхийг шалгах зорилгоор аливаа нэг хүн эсвэл баг ажиллуулж байгаа талаар тодруулж өгнө үү</p> <p>Жишээлбэл, бид 5-р сарын 5-ны өдөр тендерийн баримт бичгийн төслийг урьдчилсан байдлаар илгээхээр төлөвлөж байгаа бөгөөд уг баримт бичгийг та болон танай</p>	<p>X.4 Таны гаргасан хүсэлт нь ашиг сонирхлын зөрчил үүсгэх боломжтой тул урьдчилан бэлтгэсэн баримт бичгийг хянах ажилтныг томилох боломжгүй. Өргөдөл гаргагчид баримт бичгээ тогтоосон удирдамжийн дагуу нарийн мөрдөж бэлтгэн, илгээх үүрэгтэй. Хэрэв удирдамжийн аль нэг хэсэгт тодруулга шаардлагатай бол бүх оролцогчдод тэгш мэдээлэл хүргэх үүднээс манай яамны албан ёсны www.mmhi.gov.mn цахим хуудсанд байршуулсан сонгон</p>

<p>хамт олон хянаж, аливаа алдаа, дутуу мэдээлэл байвал бидэнд мэдэгдэх боломжтой юу? Ингэснээр бид албан ёсны хугацаанаас өмнө шаардлагатай засвар, сайжруулалтыг хийх хангалттай хугацаатай байх юм.</p>	<p>шалгаруулалтын зар тавигдсан хэсэгт хавсаргагдах болно.</p>
--	--